



**ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /Маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа:	2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"Гермес Центр" ХК УБГД: 9010001069 Үнэт цаасны код: MN00HRM05287 Утасны дугаар: (+976) 11 301 577
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр:	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар :	Түрээс
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:	78 543 001
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Жилийн тайланг бэлтгэсэн: Нягтлан бодогч О.Энхтуяа ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэн Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг

1 Тайлант жилийн санхүүгийн тайлан (хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана.)

	Огноо	2022.01.01	2022.12.31
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Санхүү байдлын үзүүлэлт	Үзүүлэлт		
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	2,400,179,444.28	2,683,718,091.98
	Эргэлтийн бус хөрөнгө	6,218,744,828.04	6,059,057,008.83
	Нийт хөрөнгө	8,618,924,272.32	8,742,775,100.81
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	258,066,974.87	285,321,309.41
	Урт хугацаат өр төлбөр	-	-
	Эздийн өмч	8,360,857,297.45	8,457,453,791.40
Нийт өр төлбөр ба эздийн өмч	8,618,924,272.32	8,742,775,100.81	
Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Борлуулалтын орлого	1,525,159,558.83	2,059,006,005.73
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
	Нийт ашиг	1,525,159,558.83	2,059,006,005.73
	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	1,042,231,799.33	1,383,407,936.98
	Орлогын татварын зардал	104,473,181.24	138,339,377.57
	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	937,758,618.09	1,245,068,559.41
	Нийт орлогын дүн	937,758,618.09	1,245,068,559.41
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Өмч	7,854,300,100.00	7,854,300,100.00
	Хуримтлагдсан ашиг	506,557,197.45	603,153,691.40
	Нийт эздийн өмчийн дүн	8,360,857,297.45	8,457,453,791.40

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	889,005,356.31	1,120,787,530.70
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	216,685,065.47	236,452,787.71
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(818,939,185.94)	(1,062,822,883.44)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	286,751,235.84	294,417,434.97
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,023,254,899.94	2,310,006,135.78
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,310,006,135.78	2,604,423,570.75
	1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
<i>Аудитын тайлан дүгнэлтийг хавсаргав.</i>			
1.2	Аудитын тодорхойлох захидал (тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурьдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх)		
<i>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</i>			
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл		
2.1	Үйл ажиллагааны үр /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд	$ROA = 0.1424$ $ROE = 0.1472$ $EPS = 15.85$	
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	$ROTA = 0.16$	
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<i>Манай компанийн харилцагч түрээслэгчдэд учирч байгаа валютын ханшийн өсөлт, гадаад, дотоод тээвэр логистикийн асуудал, нийтийг хамарсан цар тахлын өвчлөл зэрэг нь бидний үйл ажиллагаанд сөрөг нөлөөллийг үзүүлж, түрээсийн төлбөр төлөлтөнд удаашралыг бий болгодог. Компанийн зүгээс түрээсийн үнэ тарифыг ижил төстэй худалдааны төвүүдээс бага байлгах бодлогыг баримталж ажилладаг бөгөөд ингэснээр түрээслэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд эерэг нөлөөллийг үзүүлдэг. Үүний үр дүнд компанийн мөнгөн урсгалыг зөв зохистой удирдаж, компанийн ашгийг нэмэгдүүлэхэд түлхэц болж байна.</i>	
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого (off balance)	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</i>	
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл:	<i>Тайлант хугацаанд авсан зээл болон зээлийн баталгаа байхгүй.</i>	
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана./		
<i>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</i>			
4	Цалин урамшууллын мэдээлэл:		

Гус компани нь 2022 онд ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад дараах цалин хөлс, урамшууллыг олгосон болно. Үүнд:

1. ТУЗ-ийн цалинд 13.5 сая төгрөг олгосон.

2. Гүйцэтгэх захирлын цалинд 61.6 сая төгрөг, ТУЗ-ийн даргатай байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний 2.7.2-р заалтын дагуу 20.0 сая төгрөгийн урамшууллыг олгосон.

5 Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:

"Гермес Центр" ХК нь Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд багтдаг нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Бид компанийн үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшигаас хамгаалах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль зэрэг хуулиудыг болон Компанийн засаглалын кодексыг, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан холбогдох дүрэм, журмыг баримталж ажилладаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Манай компанийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 15-ны өдөр 86.02%-ийн хурлын ирцтэйгээр хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлав.

2. Компанийн ТУЗ-ийн 2022 оны төсвийг хэлэлцэн батлав.

Төлөөлөн Удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байдаг. Компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүнийг 5 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сонгосон. Одоогоор манай компанийн Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй. Манай компанийн ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн дарга нар нь компанийн засаглалын сургалтанд бүрэн хамрагдсан, банк, санхүү, бизнес, хууль эрхзүйн мэргэжилтэй удирдах ажилтнууд байдаг. Компанийн ТУЗ-ийн дэргэд Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороод ажилладаг бөгөөд дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Цалин урамшууллын хороо - Дарга Д.Оюунсүрэн, гишүүд Д.Алтанчимэг, Н.Мөнхзул

2. Нэр дэвшүүлэх хороо - Дарга Б.Оюунцэцэг, гишүүд Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал

3. Аудитын хороо - Дарга Д.Туяа, гишүүд Н.Батсайхан, Б.Алтангэрэл

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон тэдгээрийн эзэмшигч буй хувьцааны талаарх танилцуулга



ТУЗ-ийн дарга

- Дугаржав овогтой Оюунсүрэн
- Инженер эдийн засагч
- "Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- Компанийн 29.8%-ийн хувьцаа эзэмшигч



ТУЗ-ийн ердийн гишүүн

- Батсүх овогтой Оюунцэцэг
- Инженер-эдийн засагч, бизнесийн удирдлагын менежер
- "Гермес Центр" ХК-ийн гүйцэтгэх захирал
- Компанийн 0.1%-ийн хувьцаа эзэмшигч



ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга

- Дашцэрэн овогтой Туяа
- Эдийн засагч
- "Төрийн банк" ХК-ийн хэлтсийн захирал
- Компанийн хувьцаа эзэмшдэггүй



ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Нямжав овогтой Батсайхан
- Эдийн засагч
- "Монгол даатгал" ХХК-ийн Чингэлтэй салбарын захирал
- Компанийн хувьцаа эзэмшдэггүй



ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Балжинням овогтой Алтангэрэл
- Банкны эдийн засагч
- "Ар гурван хэц" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- Компанийн хувьцаа эзэмшдэггүй



ТУЗ-ийн ердийн гишүүн

- Дүвчиндорж овогтой Алтанчимэг
- Нягтлан бодогч
- "Одод" ХХК-ийн нягтлан бодогч
- Компанийн 2%-ийн хувьцаа эзэмшигч



ТУЗ-ийн ердийн гишүүн

- Намсрай овогтой Мөнхзул
- Эдийн засагч
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Компанийн хувьцаа эзэмшдэггүй



ТУЗ-ийн ердийн гишүүн

- Цээнсүрэн овогтой Түвшинжаргал
- Зураач
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Компанийн 0.06%-ийн хувьцаа эзэмшигч



ТУЗ-ийн ердийн гишүүн

- Буянцог овогтой Амарсанаа
- Эрхзүйч
- "Төрийн банк" ХК-ийн хуулийн хэлтсийн захирал
- Компанийн хувьцаа эзэмшдэггүй

Өнгөрсөн 2022 онд манай компанийн ТУЗ нь 4 удаа танхимаар хуралдаж, нийт 15 тогтоол шийдвэрүүдийг гаргасан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь улирал тутам хуралдаж, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх санал дүгнэлтээ гаргаж, СЗХ болон МБХ-д цахимаар болон хэвлэмэл байдлаар хүргүүлж хэвшсэн.

Компанийн засаглалын кодекс

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №145 тоот тогтоолоор "Компанийн засаглалын кодекс" шинэчлэн батлагдсан. Үүний дагуу манай компанийн ТУЗ -өөс Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталж, улмаар дараах бодлогын баримт бичиг, заавар, журмыг кодексийн зарчимд нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталлаа. Үүнд:

- Компанийн засаглалын кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөр
- Компанийн ёс зүйн дүрэм
- Компанийн залгамж халааны бодлого
- Компанийн цалин урамшууллын бодлого

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого

Компанийн дотоод хяналтын заавар

Компанийн комплайнсын хяналтын заавар

Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам

Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам

Компанийн ТУЗ-ийн хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс СЗХ болон МХБиржид хэвлэмэл байдлаар тогтмол хүргүүлж, мөн www.mse.mn, www.hermescenter.mn сайтуудад байршуулан олон нийтэд нээлттэй ил тодоор тайлагнан ажиллаж байна.

6 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Манай компани нь барилгын материалын бизнес эрхлэгчдэд худалдааны талбайн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бидний үйл ажиллагаанд валютын ханш болон бараа материалын үнийн өсөлт, улс хоорондын тээвэр логистик, нийтийг хамарсан цар тахал өвчин, төр засгийн гэнэтийн шийдвэрүүд (цахилгааны үнийн өсөлт 28%) голлох эрсдлүүдийг бий болгодог.

7 Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл (5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо)

Манай компани нь 2022 оны 9-р сарын 16-ны бүртгэлийн өдрөөр нийт 1024 хувьцаа эзэмшигчидтэй байсан. Компанийн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчид нь иргэн Д.Зоригт (42 530 145 ширхэг хувьцаатай буюу 54.1%) болон иргэн Д.Оюунсүрэн (23 460 015 ширхэг буюу 29.8%) нар тус тус эзэмшиж байна.

8 Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл:

Олон нийтэд шинээр санал болгон хувьцаа гаргаагүй болно.

9 Ногдол ашгийн мэдээлэл :

Манай компани нь санхүүгийн тайландаа хагас болон бүтэн жилээр 2 удаа аудит хийлгэж, жилдээ 2 удаа ногдол ашиг хуваарилдаг бөгөөд ногдол ашиг тараалтын тайланг холбогдох журмын дагуу СЗХ, МХБирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол тайлагнаж ирсэн.

1. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 2-р сарын 16-ны өдрийн хурлын 2 тоот тогтоолын дагуу 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 499.5 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 6 төгрөг 36 мөнгө байсан. 2022 оны 3-р сарын 10-ны бүртгэлийн өдрөөр нийт 1004 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас 6 хувьцаа эзэмшигчдийн 67 293 611 ширхэг хувьцааны ногдол ашиг болох 427.9 сая төгрөгийг компани дээр бэлэн мөнгөөр, 998 хувьцаа эзэмшигчдийн 11 249 390 ширхэг хувьцааны ногдол ашиг болох 71.5 сая төгрөгийг ҮЦТХТөвтэй гэрээ байгуулж бэлэн бусаар тараасан.

2. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 8-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрээр 2022 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 629.9 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 8 төгрөг 02 мөнгө байсан. 2022 оны 9-р сарын 16-ны бүртгэлийн өдрөөр нийт 1018 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгаас 6 хувьцаа эзэмшигчдийн 67 293 611 ширхэг хувьцааны ногдол ашиг болох 539.7 сая төгрөгийг компанийн төв байранд дээр бэлнээр, 1012 хувьцаа эзэмшигчдийн 11 249 390 ширхэг хувьцааны ногдол ашиг болох 90.2 сая төгрөгийг ҮЦТХТөвтэй гэрээ байгуулж тараасан болно.

10 Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл :

Манай компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсадаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна.

2. Худалдааны төвийн захиргаа нь "Непко кидс" ХХК-тай завгүй эцэг эхчүүдэд зориулсан дэлхийн сонгодог уран зохиол болон хүүхдийн номын өдөрлөгийг хамтран зохион байгуулж ажилласан нь иргэдийн оюуны хөрөнгө оруулалтанд хувь нэмрээ оруулсан үйл явдал болсон.

3. "Монос" групп-тэй хамтран "Дархлаа дэмжсэ" аяныг иргэдийнхээ дунд зохион байгууллаа. Аяны хүрээнд ясны сийрэгжилт, цусны даралт, хүчилтөрөгчийн дутагдал үзэх зэргээр эмнэлгийн анхан шатны үзлэг оношилгоог хийж, улмаар түрээслэгч иргэдэд витаминь зөв зохистой хэрэглээний талаар мэргэжлийн эмч зөвлөгөөг өгч ажиллалаа.

4. Худалдааны төвийн захиргаа нь Баянгол дүүрэг дэхь Цагдаагийн хэлтэстэй хамтран Улсын хэмжээнд зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал, хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах зорилгоор зохион байгуулагдсан "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нөлөөллийн аянд нэгдэж түрээслэгчид, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудад болон худалдан авагч иргэдэд мэдээ мэдээллийг өргөн хүрээнд өгч хамтран ажиллалаа.

5. Баянгол дүүргийн цахилгаан түгээх сүлжээ төвтэй хамтран худалдааны төвийн түрээслэгчдэд эрчим хүчний хэрэглээгээ боломжит хэмжээгээр хэмнэх, зөв зохистой хэрэглэх талаар тогтмол таниулан сурталчлах ажлыг хийж байна. Үүний үр дүнд эрчим хүчийг тодорхой хэмжээнд хэмнэж, улс орныхоо өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллалаа.

6. Худалдааны төвийн эргэн тойрон дахь ногоон байгууламжийг байнга тордож, шинээр шар хуайс суулгаж, иргэдээ эрүүл, ая тухтай, цэвэр цэмцгэр орчинд таатай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

7. Манай худалдааны төвийн захиргаа нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, иргэд, түрээслэгчдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх ажлыг цогцоор нь шийдвэрлэн ажилласан. Энэхүү ажлын хүрээнд худалдааны төвийн хашаанд байрлах хогийн савыг төрөлжүүлэн хувааж будсан бөгөөд түрээслэгч иргэдэд хог хаягдлаа эх үүсвэр дээр нь зөв ангилж хаях дадал зуршлыг хэвшүүлж байна. Үүний үр дүнд 2022 онд 10 гаруй тонн цаасан хог хаягдал болон ус ундааны хуванцар сав, шил зэргийг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт тушаасан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Оюунцэцэг

Албан тушаал: "Гермес Центр" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: УЛААНБААТАР.ХО

(Тамга тэмдэг)

ГЕРМЕСЦЕНТР
ХК

ТТБ 4437-4 2771878

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2023 оны 02-р сарын 01-ны өдөр

Овог, нэр: Д.Эрдэнэсүрэн

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Гарын үсэг: Д. Эрдэнэсүрэн